

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Даланзадгадын Дулаан хангамж ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: **ӨМА-2025/017/НА-СТА-ОНӨҮГ**

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Өмнөговь аймаг 2025 он	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас: 70533539 Цахим хаяг: <a href="mailto:usukhbayarts@audit.gov.mn">usukhbayarts@audit.gov.mn</a> Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: <a href="mailto:khongorzult@audit.gov.mn">khongorzult@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Б.Алтанцэцэг Утас: 8000-7121 Цахим хаяг: <a href="mailto:tolinetugen@gmail.com">tolinetugen@gmail.com</a> Толин этүгэн аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал: Б.Отгон-Өлзий Утас: 99844655 Цахим хаяг: <a href="mailto:otgon1118@yahoo.com">otgon1118@yahoo.com</a>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан .....	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	4
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.5 Зорилтот түвшний төлөвлөгөө гүйцэтгэл.....	<b>Error! Bookmark not defined.</b>
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	7
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	7
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	7
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	8
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	92
4.1 Ерөнхий зүйл .....	9
4.2 Материаллаг байдал.....	9
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	9
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	9
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	10
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	10
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	10
5.1 Төлбөрийн акт .....	<b>Error! Bookmark not defined.</b>
5.3 Зөвлөмж .....	10
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	16

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2025.03.14 № 259  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

ДАЛАНЗАДГАДЫН ДУЛААН  
ХАНГАМЖ ОНӨААТҮГ-ЫН ДАРГА  
Б.МӨНХ-АМАР ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Даланзадгадын Дулаан хангамж ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг, бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 6,905,871.8 мянган төгрөгийн барилга байгууламж, 341,395.4 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 843,580.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 460.0 мянган төгрөгийн архивын шүүгээ, 8,745.9 мянган төгрөгийн компьютер нийлүүлэгдэж бүртгэлд авсан байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд 3,811.5 мянган төгрөгийн ашигтай ажиллахаар бизнес төлөвлөгөө батлуулан гүйцэтгэлээр 91,811.6 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Энэ нь элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.

4625020515

F:\2.Бичиг хэрэг\2025он\СТА-н дүгнэлт\Төсөл.Досх

**Бусад асуудлын хэсэг**

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлтэд бусад мэдээлэл хэсэгт тусгасан асуудал нь хамрахгүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>783,563,299.27</b>	<b>955,195,666.46</b>
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	557,678,041.41	710,906,582.47
1.1.2	Дансны авлага	115,019,784.54	145,965,411.13
1.1.3	Бусад авлага		122,255.20
1.1.6	Бараа материал	110,865,473.32	98,201,417.66
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>783,563,299.27</b>	<b>955,195,666.46</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>18,534,508,898.38</b>	<b>25,731,581,475.51</b>
1.2.1	Үндсэн хөрөнгө	18,439,496,261.23	25,719,596,883.40
1.2.2	Биет бус хөрөнгө	17,012,637.15	11,984,592.11
1.2.3	Бусад эргэлтийн бус хөрөнгө	78,000,000.00	
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>18,534,508,898.38</b>	<b>25,731,581,475.51</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>19,318,072,197.65</b>	<b>26,686,777,141.97</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>	<b>20,408,169,330.63</b>	<b>27,868,685,887.55</b>
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>	<b>200,226,572.55</b>	<b>217,754,782.99</b>
2.1.1.1	Дансны өглөг	183,862,802.58	193,665,701.14
2.1.1.3	Татварын өр	16,363,769.97	24,089,081.85
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат өр төлбөр	20,207,942,758.08	27,650,931,104.56
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>20,207,942,758.08</b>	<b>27,650,931,104.56</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>20,408,169,330.63</b>	<b>27,868,685,887.55</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>	<b>(1,090,097,132.98)</b>	<b>(1,181,908,745.58)</b>
2.3.1	Өмч: - хувийн	320,008,928.00	320,008,928.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	15,575,351.99	15,575,351.99
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	6,226,000.00	6,226,000.00
2.3.9	Хуримтлагдсан (алдагдал)	(1,431,907,412.97)	(1,523,719,025.57)
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>(1,090,097,132.98)</b>	<b>(1,181,908,745.58)</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>19,318,072,197.65</b>	<b>26,686,777,141.97</b>

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	3,162,309,346.20	4,053,439,134.38
2	Борлуулалтын өртөг	3,451,695,274.62	4,671,134,897.71
<b>3</b>	<b>Нийт ашиг</b>	<b>(289,385,928.42)</b>	<b>(617,695,763.33)</b>
4	Бусад орлого	479,755,668.06	817,742,914.52
5	Ерөнхий ба удирдлагын зардал	225,291,184.44	291,858,763.79
6	Бусад ашиг алдагдал	(40,090.85)	
<b>7</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(34,961,535.65)</b>	<b>(91,811,612.60)</b>
8	Орлогын татварын зардал		
<b>9</b>	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(34,961,535.65)</b>	<b>(91,811,612.60)</b>
<b>10</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>(34,961,535.65)</b>	<b>(91,811,612.60)</b>
11	Бусад дэлгэрэнгүй орлого		-
<b>12</b>	<b>Орлогын нийт дүн</b>		
13	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		-

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт дүн
----------	-----	-----------------	---------------------------	-------------------------------	----------

**Өмнөговь аймгийн Даланзадгадын Дулаан хангамж ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

		<b>үнэлгээний нэмэгдэл</b>			
<b>2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>320,008,928.00</b>	<b>15,575,351.99</b>	<b>6,226,000.00</b>	<b>(1,431,907,412.97)</b>	<b>(1,090,097,132.98)</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-		0.01	0.01
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>320,008,928.00</b>	<b>15,575,351.99</b>	<b>6,226,000.00</b>	<b>(1,431,907,412.97)</b>	<b>(1,090,097,132.98)</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(91,811,612.60)	(91,811,612.60)
<b>2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>320,008,928.00</b>	<b>15,575,351.99</b>	<b>6,226,000.00</b>	<b>(1,523,719,025.57)</b>	<b>(1,181,908,745.58)</b>

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>3,566,756,499.44</b>	<b>4,325,181,478.41</b>
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,448,012,113.16	2,735,707,906.90
	Бусад мөнгөн орлого	1,118,744,386.28	1,589,473,571.51
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>3,249,659,945.92</b>	<b>4,169,147,937.35</b>
	Ажиллагчдад төлсөн	779,035,292.97	1,131,833,781.82
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	248,709,517.42	342,503,734.08
	Бараа материал худалдан авахад төлсөн	318,676,859.00	642,314,475.00
	Ашиглалтын зардалд төлсөн	1,145,676,677.61	1,363,919,133.35
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	94,926,154.00	170,462,590.03
	Татварын байгууллагад төлсөн	226,488,443.87	347,375,373.28
	Даатгалын төлбөрт төлсөн	81,675.00	382,860.00
	Бусад мөнгөн зарлага	436,065,326.05	170,355,989.79
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>317,096,553.52</b>	<b>156,033,541.06</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	-	-
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	-	<b>2,805,000.00</b>
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		2,805,000.00
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	-	<b>(2,805,000.00)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	-	
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	-	-
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	-	-
4.2	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	317,096,553.52	153,228,541.06
<b>5.1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>240,581,487.89</b>	<b>557,678,041.41</b>
<b>5.2</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>557,678,041.41</b>	<b>710,906,582.47</b>

**2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ЗӨРҮҮ
	Ашиглалтын зардал	1,646,362,648.02	1,331,624,282.07	(314,738,365.95)
1	ДЭХ-ний зардал	1,477,896,533.28	1,201,142,322.77	(276,754,210.51)
2	ДЭХ контор	4,414,483.59	2,279,787.30	(2,134,696.29)
3	Цэвэр ус	2,786,110.80	2,114,077.36	(672,033.44)
4	Нэмэлт ус	4,947,800.00	3,661,980.00	(1,285,820.00)
5	Цахилгааны зардал	156,317,720.35	122,426,114.64	(33,891,605.71)
Цалин		1,629,902,241.78	1,395,920,555.50	(233,981,686.28)

**Өмнөговь аймгийн Даланзадгадын Дулаан хангамж ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

6	Үндсэн цалин	616,920,923.52	557,650,653.46	(59,270,270.06)
7	УЖНэмэгдэл	330,996,196.44	96,427,015.33	(234,569,181.11)
8	Сарын үр дүн	127,233,383.65	117,332,405.45	(9,900,978.20)
9	Хоолны хөнгөлөлт	114,912,000.00	88,629,000.00	(26,283,000.00)
10	ЭХТА	1,440,000.00	1,155,000.00	(285,000.00)
11	Хавсран	3,772,800.00	12,449,649.31	8,676,849.31
12	ЭА	83,815,491.01	99,832,545.05	16,017,054.04
13	Шөнийн цаг	83,094,163.26	79,705,363.09	(3,388,800.17)
14	амралт баяр ёслол	9,824,888.83	11,732,059.82	1,907,170.99
15	Илүү цаг	20,054,307.50	16,326,542.34	(3,727,765.16)
16	Нутгийн дэм	-	90,773,069.04	90,773,069.04
17	ТУЗ цалин	37,620,000.00	35,095,792.00	(2,524,208.00)
18	ЖҮДШагнал	200,218,087.56	188,811,460.61	(11,406,626.95)
НДШимтгэл		230,880,925.06	188,524,542.62	(42,356,382.44)
19	НДШимтгэл	230,880,925.06	188,524,542.62	(42,356,382.44)
Бусад		530,113,600.00	604,483,070.71	74,369,470.71
20	Засварын зардал	249,357,200.00	325,383,378.39	76,026,178.39
21	Аварын нөөц	36,667,500.00	-	(36,667,500.00)
22	Томилолтын зардал	43,034,200.00	-	(43,034,200.00)
23	Механизмын зардал	39,370,000.00	96,945,407.47	57,575,407.47
24	Цэвэрлэгээний зардал	1,586,800.00	1,262,728.83	(324,071.17)
25	ТУЗ зардал	6,695,500.00	-	(6,695,500.00)
26	Бичиг хэргийн зардал	5,387,300.00	13,763,141.50	8,375,841.50
27	ХХАА-ны зардал	43,159,000.00	59,863,058.80	16,704,058.80
28	Галын аюулаас хамгаалах	8,120,000.00	297,000.00	(7,823,000.00)
29	Гамшигаас хамгаалах	7,355,000.00	458,465.00	(6,896,535.00)
30	Байгаль орчин	733,000.00	-	(733,000.00)
31	Зар сурталчилгааны зардал	15,745,000.00	18,577,636.35	2,832,636.35
32	Шуудан холбооны зардал	23,753,500.00	4,626,802.98	(19,126,697.02)
33	Даатгал /техник/	2,319,200.00	509,053.00	(1,810,147.00)
34	Шатахууны зардал	46,830,400.00	82,796,398.39	35,965,998.39
Аж/нийгэм зардал		66,534,300.00	1,159,340,904.80	1,092,806,604.80
35	баяр ёслол, биеийн тамир	4,300,000.00	1,542,181.82	(2,757,818.18)
36	Шагнал	2,000,000.00	600,000.00	(1,400,000.00)
37	Түлшний хөнгөлөлт	6,800,000.00	6,800,000.00	-
38	Ахмадын зардал	6,600,000.00	6,026,000.00	(574,000.00)
39	Тэтгэмж, тусламж	8,400,000.00	2,600,000.00	(5,800,000.00)
40	Сургалтын зардал	33,434,300.00	15,439,654.09	(17,994,645.91)
41	Элэгдэл	-	1,091,744,433.87	1,091,744,433.87
42	Бусад зардал	5,000,000.00	34,588,635.02	29,588,635.02
Хөрөнгийн зардал		40,160,900.00	-	(40,160,900.00)
1	Тоног төхөөрөмж	40,160,900.00	-	(40,160,900.00)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН		4,143,954,614.85	4,679,893,355.70	535,938,740.85
1	Борлуулалтын орлого	2,813,973,126.26	3,390,270,218.60	576,297,092.34
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		2,813,973,126.26	3,390,270,218.60	576,297,092.34
1	Үйл аж/гааны бус орлого	1,443,623,000.00	1,480,911,830.30	37,288,830.30
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		1,443,623,000.00	1,480,911,830.30	37,288,830.30
1	Үйл аж/гааны бус зардал	109,830,000.00	283,100,305.80	173,270,305.80
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		109,830,000.00	283,100,305.80	173,270,305.80
НИЙТ ОРЛОГЫН ДҮН		4,257,596,126.26	4,871,182,048.90	613,585,922.64
НИЙТ ЗАРДЛЫН ДҮН		4,253,784,614.85	4,962,993,661.50	709,209,046.65
Нийт ашиг/алдагдал		3,811,511.40	(91,811,612.60)	(95,623,124.00)

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Компани, түүний үйл ажиллагаа

Даланзадгадын Дулаан хангамж ОНӨААТҮГ нь Өмнөговь аймгийн Даланзадгадын сумын иргэд, аж ахйн нэгжид дулааны эрчим хүчийг үйлдвэрлэн зохицуулалттай түгээх, шугам сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээ, өргөтгөл, шинэчлэлтийн ажлуудыг чанартай гүйцэтгэж хэрэглэгчдийн ая тухыг хангасан халаалтын үйлчилгээний тэргүүлэгч байгууллага, мэргшсэн хамт олон байхад оршино гэсэн зорилготой ажиллаж байна. Тус байгууллага нь дулааныг үйлдэрлэх, зохицуулалттай хангах чиглэлээр үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

#### 3.2 Компанийн гадаад, дотоод орчин

Компани нь үйл ажиллагааг явуулахдаа Эрчим хүчний тухай хууль, Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Монгол Улсын Иргэний хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;
- Нийгмийн даатгалын ерөнхий хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /Шинэчилсэн найруулга/;
- Засгийн газрын 2024 оны 01 сарын 03-ний өдрийн 02 дугаар “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” тогтоол;
- Сангийн сайдын 2024 оны 04 сарын 01-ний өдрийн А52 дугаар “Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай” тушаал;
- Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 05 сарын 31-ний өдрийн 504 дүгээр “Аргачлал батлах тухай” тогтоол;
- Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 12 сарын 06-ны өдрийн 708 дугаар “Тарифт өөрчлөлт оруулах тухай” тогтоол;

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Даланзадгадын Дулаан хангамж ОНӨААТҮГ нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

**Өмнөговь аймгийн Даланзадгадын Дулаан хангамж ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

Даланзадгадын Дулаан хангамж ОНӨААТҮГ нь 2015 онд батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдлөг болгон ажиллаж байна.

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Даланзадгадын Дулаан хангамж ОНӨААТҮГ нь 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “ Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,368,704.9 мянган төгрөгөөр буюу 38.1 хувиар өссөн байна. Энэ нь аймгийн Өмнөговь аймгийн хөрөнгө оруулалтаар 6,905,871.8 мянган төгрөгийн барилга байгууламж, 341,395.4 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 843,580.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 460.0 мянган төгрөгийн архивын шүүгээ, 8,745.9 мянган төгрөгийн компьютер, нийт 8,100,053.2 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэж авсанаас шалтгаалсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	557,678.0	710,906.6	153,228.5
Дансны авлага	115,019.8	145,965.4	30,945.6
Бусад авлага	-	122.3	122.3
Бараа материал	110,865.5	98,201.4	(12,664.1)
Үндсэн хөрөнгө	18,534,508.9	25,731,581.5	7,197,072.6
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>19,318,072.2</b>	<b>26,686,777.1</b>	<b>7,368,704.9</b>
Богино хугацаат өр төлбөр	200,226.6	217,754.8	17,528.2
Урт хугацаат өр төлбөр	20,207,942.8	27,650,931.1	7,442,988.3
Эздийн өмчийн дүн	(1,090,097.1)	(1,181,908.7)	(91,811.6)
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>19,318,072.2</b>	<b>26,686,777.1</b>	<b>7,368,704.9</b>

Дээрх хүснэгтээс харахад дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд :

- Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл 153,228.5 мянган төгрөг болж 27.5 хувиар өссөн байна.
- Дансны авлагын үлдэгдэл 31,067.9 мянган төгрөг болж 26.9 хувиар өссөн байна.
- Бараа материалын үлдэгдэл 98,201.4 мянган төгрөг болж 11.4 хувиар буурсан байна.
- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл нь 7,197,072.6 мянган төгрөг болж 38.8 хувиар өссөн нь хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн үндсэн хөрөнгөтэй холбоотой байна.
- Урт хугацаат өглөг дансанд үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийг хойшлогдсон орлогоор бүртгэж тусгасан байна.

**3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Даланзадгадын Дулаан хангамж ОНӨААТҮГ нь санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Тайлант 2024 онд нийт орлогыг 4,257,596.1 мянган төгрөгөөр, нийт зардлыг 4,253,784.6 мянган төгрөгөөр, нийт 3,811.5 мянган төгрөгийн ашигтай ажиллахаар батлуулсан байна.

Гүйцэтгэлээр 4,871,182.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 4,962,993.7 мянган төгрөгийн зардал гарган 91,811.6 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Хүснэгт 2. Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
----------	------------	-----------	-------

**Өмнөговь аймгийн Даланзадгадын Дулаан хангамж ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

	1	2	3=2-1
Нийт орлого	4,257,596.1	4,871,182.0	613,585.9
Нийт зардал	4,253,784.6	4,962,993.7	709,209.0
Татвар төлөхийн өмнөх ашиг алдагдал	3,811.5	(91,811.6)	(95,623.1)

Батлагдсан зорилтот түвшин, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Өмнөговь аймгийн Даланзадгадын Дулаан хангамж ОНӨААТҮГ нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах дансны өглөг, албан хэрэг хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Толин этүгэн аудит ХХК-ийн аудитын аудитор Б.Эрдэнэчимэг, ахлах аудитор Б.Алтанцэцэг нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг чанарын хяналтын менежер Д.Гэрэлхүү, хоёр дахь шатны хяналтыг гүйцэтгэх захирал Б.Отгон-Өлзий нар гүйцэтгэж, чанарын хяналтыг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ж.Болормаа, аудитын менежер Т.Хонгорзул, дарга, тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Өмнөговь аймгийн Даланзадгадын Дулаан хангамж ОНӨААТҮГ нь 2024 оны санхүүгийн тайланг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 3,451,699.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 51,775.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага үндсэн цалин, гэрэл цахилгаан, түлш халаалт, шуудан холбоо интернэтийн зардлуудыг хэмнэж ажилласан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд тусгайлан аудит хийгдээгүй болно.

#### 4.5 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 3.

Зөвлөмжийн хэрэгжилт

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	4	15,685.3	4	15,685.3	100.0
Нийт дүн	4	15,685.3	4	15,685.3	100.0

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Үндсэн хөрөнгө болон бараа материалын үлдэгдлийг тулган баталгаажуулах шаардлагатай.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 88,860.1 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрсэнд 1 зөвлөмж өгч ажилласан.

#### 5.1 Зөвлөмж

##### Илрүүлэлт: 1

2024 онд И Эн Би Ай ХХК-аас 50.290.1 мянган төгрөгийн шугам хоолойн материал, Бат Зэт Ти ХХК-аас 38,570.0 мянган төгрөгийн цемент, нийт 88,860.1 мянган төгрөгийн бараа материалын шууд худалдан авалт хийсэн байна.

##### Өгсөн зөвлөмж:

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 10.3.Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно, 18.1.Захиалагч энэ хуулийн 10.2-т заасан шууд худалдан авч болох төсөвт өртгөөс дээш тендер шалгаруулалтын зарлалыг тендер шалгаруулалтын баримт бичгийн хамт цахим системд нийтэлж, аж ахуй эрхлэгчийг танилцах боломжоор хангана, ЗГ-ын 2024.01.03-ний өдрийн 02 дугаар тогтоолоор батлагдсан “худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” тогтоолыг хэрэгжүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

(мянган төгрөгөөр)

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1													
	Дүн												

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хяналтын байгууллагад шилжүүлсэн	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2024 онд И Эн Би Ай ХХК-аас 50.290.1 мянган төгрөгийн шугам хоолойн материал, Бат Зэт Ти ХХК-аас цемент, нийт 88,860.1 мянган төгрөгийн бараа материалын шууд худалдан авалт хийсэн байна.	1	88,860.1					1	88,860.1		
Нийт	1	88,860.1					1	88,860.1	-	-

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
<b>Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Дүн								